

# “ХАРХОРИН” ХК
# 2014 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХАРХОРИН ХК
ТТБ2042 ... 2015471



## 1. “ Хархорин “ ХК-ний агроүйлдвэрлэлийн талбайн байгаль цаг уурын онцлог






мөндөрийн хэмжээ( 4,0 – 4,5 см )

Мөндөртэй аадар бороо орж байгаа нь

4,0 – 4,5 см диаметр хэмжээтэй том, олон цөмт нийлмэл мөндөр бүхий аадар бороо 15 минутын турш орсон.



## Мөндөрөөс болж учирсан хохирол









Мөндөртэй аадар борооны дараахи талбайн жимслэх модны байдал ( 6-р сарын 23 )

Дээрх хугацаанд орсон мөндөр нь таримал ургамалд 5-45 хувийн хохирол учруулсан.



## Мөндөрөөс болж учирсан хохирол





Мөндөртэй аадар борооны дараахи үхэр нүдний талбайн жимслэх модны байдал ( 6-р сарын 23 )

5-р сарын 15-аас 6-р сарын 15-ны хооронд үхэр нүдний жимслэх талбай хариуцсан 1 ба 4-р бригадуудын цэцэрлэгчид, агрономчид цаг уурын мэдээг харгалзан цаг тухай бүрд нь хярууны хамгаалалтанд шөнийн цагаар гарч овоолго, утааны шашек шатаах үйл ажиллагаа явуулсан. Гэвч 6-р сарын 23-нд том ширхэгтэй нийлмэл мөндөр үхэр нүдний жимслэх талбайг хамарч орсоноос шалтгаалан жимс гөвөгдөж унасан.



## Мөндөрөөс болж учирсан хохирол









Мөндөртэй аадар борооны дараахи хүлэмжийн талбайн байдал
( 6-р сарын 23 )

Мөндөрийн хүчтэй хуй салхинд 2 хүлэмжний рам нумарч гэмтсэн. 11 хүлэмжний хучлага олон газар цоорсон бөгөөд 6 хүлэмжний хучлагыг бүрэн ба хэсэгчлэн сольсон.



## Мөндөрөөс болж учирсан хохирол







Мөндөртэй аадар борооны дараахи талбайн жимслэх модны байдал
( 6-р сарын 23 )

Ойн зурвасын 15-20 см диаметртэй бүдүүн мод, мөчирүүд болон залуу мөчир, найлзуур маш ихээр хугарч унасан. Мөндрөөс шалтгаалан хүлэмжний цахилгааны шит гэмтэж эрчим хүч тасарснаас хүлэмжний усалгааны ажил бараг хоёр хоногийн турш аваарын байдалтайгаар ажиллах нөхцөл үүсгэсэн.

## Аадар борооноос шалтгаалан учирсан хохирол






Мөн 6-р сарын 28-нд 20 минутын турш орсон хүчтэй аадар борооны улмаас уруйн үер буусан нь талбайн усалгааны ажилыг 7 хоногийн турш саатуулсан.

# 2. Хаврын ажлын талаар

## 2.1. Шуудуу цэвэрлэгээний ажлын талаар






Энэ жил сувгийн ёроолын лаг шаврын гүн нь дунджаар 25-30 см зузаантай байв. 1-р бригад 259 хүн/өдөрт 427 м урт сувгийн хэсгээс 584,6 $м^3$, 2-р бригад 19 хүний бүрэлдэхүүнтэйгээр 217,5 хүн/өдөрт 410,2 м урт сувгийн хэсгээс 390,9 $м^3$, 3-р бригад 242 хүн/өдөрт 341 м сувгийн урт хэсгээс 573,2 $м^3$ , 4-р бригад 32 хүний бүрэлдэхүүнтэйгээр 374 хүн/өдөрт 518 м урт сувгийн хэсгээс 775,5 $м^3$, 5-р бригад 42 хүний бүрэлдэхүүнтэйгээр 516 хүн/өдөрт 711 м урт сувгийн хэсгээс 1075,5 $м^3$ буюу нийт дүнгээрээ 3399,7 $м^3$ элс, шавар, шороог сувгаас ухаж гарган, ачиж, сувгийн далангаас холдуулж буулгасан.

# 2. Хаврын ажлын талаар

## 2.1. Шуудуу цэвэрлэгээний ажлын талаар






Энэ жил сувгийн ёроолын лаг шаврын гүн нь дунджаар 25-30 см зузаантай байв. 1-р бригад 259 хүн/өдөрт 427 м урт сувгийн хэсгээс 584,6 $м^3$, 2-р бригад 19 хүний бүрэлдэхүүнтэйгээр 217,5 хүн/өдөрт 410,2 м урт сувгийн хэсгээс 390,9 $м^3$, 3-р бригад 242 хүн/өдөрт 341 м сувгийн урт хэсгээс 573,2 $м^3$ , 4-р бригад 32 хүний бүрэлдэхүүнтэйгээр 374 хүн/өдөрт 518 м урт сувгийн хэсгээс 775,5 $м^3$, 5-р бригад 42 хүний бүрэлдэхүүнтэйгээр 516 хүн/өдөрт 711 м урт сувгийн хэсгээс 1075,5 $м^3$ буюу нийт дүнгээрээ 3399,7 $м^3$ элс, шавар, шороог сувгаас ухаж гарган, ачиж, сувгийн далангаас холдуулж буулгасан.

## 2.2. ОХУ-аас авчирсан олон төрлийн жимсний суулгацыг тариалж арчилж ургуулсан ажлын талаар




5-р сарын 2-8 хооронд ОХУ-ын Красноярскийн хязгаарын Минусинск хотын жимс, ногооны хүрээлэнд очиж намар хийсэн гэрээний дагуу олон төрлийн жимсний модны суулгац авчирсан. 5-р сарын 8-11 хооронд суулгацыг Минусинскийн хүрээлэнгээс газраар тээвэрлэн авчирч тариалсан. Хархоринд тээвэрлэж авчирсан өдөртөө буюу 5-р сарын 11-ний өдөр 10Б дугаарын бойжуулгын талбайн баруун үзүүрээс 3,5 га талбайг трактороор хагалуулж, тариалах шуудуу татуулан, бэлтгүүлээд тариалсан.



## 2.2. ОХУ-аас авчирсан олон төрлийн жимсний суулгацыг тариалж арчилж ургуулсан ажлын талаар





## 2.2. ОХУ-аас авчирсан олон төрлийн жимсний суулгацыг тариалж арчилж ургуулсан ажлын талаар

| № | Таримлын төрөл | № | Сортын нэр | Ирсэн тоо | Тоолж хүлээлцэхэд байсан тоо | Тариалагдсан тоо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Алимны төрөл | 1 | Уральское наливное | 130 | 130 | 130 |
| | Яблоня полукультурка | 2 | Синап Минусинский | 110 | 112 | 112 |
| | | 3 | Соловьевское | 60 | 60 | 60 |
| | | 4 | Алтайское Румяное | 54 | 55 | 55 |
| | | 5 | Юнга | 52 | 52 | 52 |
| | | 6 | Воспитанница | 50 | 50 | 50 |
| | | 7 | Минусинское красное | 49 | 49 | 49 |
| | | 8 | Заветное | 40 | 40 | 40 |
| | | 9 | Пепинка Алексеевой | 25 | 25 | 25 |
| | | 10 | Лия | 20 | 20 | 20 |
| | ДҮН | | | 600 | 593 | 593 |
| 2 | Үхэр нүд- Смородина Черная | 1 | Софья | 500 | 497 | 497 |
| | Улаалзгана- Смородина Красная | 2 | Сахарная | 500 | 503 | 503 |
| | ДҮН | | | 1000 | 1000 | 1000 |
| 3 | Тошлой - Крыжовник | 1 | Леденец | 100 | 101 | 101 |
| | ДҮН | | | 100 | 101 | 101 |
| 4 | Чацаргана | 1 | Алей ( эр сорт ) | 1200 | 1178 | 1178 |
| | ДҮН | | | 1200 | 1178 | 1178 |
| 5 | Нохойн хошуу- Шиповник | 1 | Витаминный | 100 | 100 | 100 |
| | ДҮН | | | 100 | 100 | 100 |
| 6 | Далан хальс | 1 | Синяя птица | 50 | 50 | 50 |
| | Жимолость | 2 | Голубое веретено | 50 | 49 | 49 |
| | ДҮН | | | 100 | 99 | 99 |
| 7 | Гүзээлзгэнэ ба Зэтгэнэ | 1 | Элиста | 150 | 158 | 158 |
| | Земляника и Клубника | 2 | Фея | 100 | 302 | 302 |
| | | 3 | Чебурашка поздняя | 350 | 206 | 206 |
| | | 4 | Фестивальная Ромашка | 200 | 360 | 360 |
| | ДҮН | | | 1000 | 1026 | 1026 |
| 8 | Бөөрөлзгөнө - Малина | 1 | Барнаульская | 200 | 206 | 206 |
| | ДҮН | | | 200 | 206 | 206 |
| | БҮХ ДҮН | | | 4300 | 4303 | 4303 |

# "ХАРХОРИН" НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 02-р сарын 16 өдөр Дугаар 01/2015 Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн 2014 оны жилийн санхүүгийн тайланг үндэслэн, Компанийн тухай хуулийн 46.1, 46.5 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. "Хархорин" Нээлттэй Хувьцаат Компани нь 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу нийт 110,057.08 мянган төгрөгийн алдагдалтай ажилласантай холбогдуулан 2014 онд ногдол ашиг хуваарилахгүй гэж тогтоосугай.
2. Ногдол ашиг хуваарилахгүй болсон тухай үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнахаар тогтоосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА П. БИШРЭЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ХАРХОРИН ХК ТТБ2042 ± 2015471

# “ХАРХОРИН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 15 оны 03-р сарын 09 өдөр | Дугаар 04/2015 | Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай

“Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн 03/2015 тоот тогтоол, Компанийн тухай хуулийн 81.5.3-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох болсонтой холбогдуулан Нэр дэвшүүлэх хорооноос санал болгосон дараах хүмүүсийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшүүлсүгэй. Үүнд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдэд:
   - ✓ П. Учрал
   - ✓ П. Бишрэл
   - ✓ О. Төмөрбаатар
   - ✓ Л. Хосбаяр
   - ✓ Ж. Энхтөр
   - ✓ Ц. Энх-Амгалан

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд:
   - ✓ Д. Баярмаа
   - ✓ С. Амгалан
   - ✓ Б. Бүрэн

Хоёр. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн нэрсийг саналын хуудсанд оруулахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА П. БИШРЭЛ

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА Ж.ЭНХТӨР

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХАРХОРИН ХК
ТТБ2042 ... 2015477



## 2.2. ОХУ-аас авчирсан олон төрлийн жимсний суулгацыг тариалж арчилж ургуулсан ажлын талаар









## 2.3. Хавар болон намар суулгац гаргаж нийлүүлсэн талаар

| № | Үзүүлэлт | Суулгацын төрөл, тоо ( ширхэгээр ) | | | | | | | Олгосон огноо | Олгосон хэлбэр | Нийлүүлсэн нийт тоо (ш) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Чацаргана | | | Үхэр нүд | Улиас | Хайлаас | Цагаан бургас | | | |
| | | эр | эм | Нийт | | | | | | | |
| | ХАВАР | | | | | | | | | | |
| 1 | Даваадагва, Өв.Баруунбаян улаан сум | 1 | 9 | 10 | 0 | 150 | 250 | 200 | 2014-05-02 | худалдсан | 610 |
| 2 | Улаанбаатар ХААЖДҮГ | | | 97750 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-08 | 2013 оны тендерийн үлдэгдэл | 160800+ 2050 (запас) = 162850 |
| 3 | Дархан-Уул ХААЖДҮГ | | | 10000 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-08 | | |
| 4 | Баянхонгор ХААЖДҮГ | | | 8750 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-08 | | |
| 5 | Дорнод ХААЖДҮГазарт | | | 4300 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-08 | | |
| 6 | Орхон ХААЖДҮГазарт | | | 12550 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-08 | | |
| 7 | Хэнтий ХААЖДҮГазарт | | | 5250 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-08 | | |
| 8 | Төв ХААЖДҮГазарт | | | 19600 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-08 | | |
| 9 | Хөвсгөл ХААЖДҮГазарт | | | 2600 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-08 | | |
| 10 | 1-р бригадын ажилчидад | | | 220 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-14 | 1000₮/ш үнээр | 220 |
| 11 | 3-р бригадын ажилчидад | | | 200 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-15 | 1000₮/ш үнээр | 200 |
| 12 | 1-р бригад Гэнэндуламд | | | 300 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-15 | 1000₮/ш үнээр | 300 |
| 13 | Граш манаач Бүрэнжаргал | | | 10 | 6 | 0 | 0 | 0 | 2014-05-14 | 1000₮/ш үнээр | 16 |
| 14 | 4-р бригадын ажилчидад | | | 1500 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-20 | 1000₮/ш үнээр | 1500 |
| 15 | 5-р бригадын ажилчидад | | | 30 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-20 | 1000₮/ш үнээр | 30 |
| 16 | Захиргаанд (цагдаагийн гүүр) | | | 0 | 0 | 40 | 0 | 30 | 2014-05-18 | хандив | 70 |
| 17 | 1-р бригад нөхөн тарилт | | | 0 | 1685 | 0 | 0 | 0 | 2014-05-22-26 | Нөхөн тарилтанд | 1685 |
| 18 | 4-р бригад нөхөн тарилт | | | 0 | 990 | 0 | 0 | 0 | 2014-05-26 | Нөхөн тарилтанд | 990 |
| 19 | Өлзийбат Улаанбаатар | 200 | 1800 | 2000 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-20 | 2013 оны тендерийн үлдэгдэл | 2000 |
| 20 | Гангар | | | 1000 | 0 | 0 | 0 | 0 | 2014-05-20 | Хоор/тооцоогоор | 1000 |
| 21 | Даваадагва, Өв.Баруунбаян улаан сум | 1 | 9 | 10 | 0 | 110 | 40 | 0 | 2014-05-29 | худалдсан | 160 |
| | Хаврын дүн | | | 166060 | 2681 | 300 | 290 | 230 | 877238 | 0 | 173681 |



## 2.3. Хавар болон намар суулгац гаргаж нийлүүлсэн талаар

| № | Үзүүлэлт | Суулгацын төрөл, тоо ( ширхэгээр ) | | | | | | | Олгосон огноо | Олгосон хэлбэр | Нийлүүлсэн нийт тоо (ш) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Чацаргана | | | Үхэр нүд | Улиас | Хайлаас | Цагаан бургас | | | |
| | | эр | эм | Нийт | | | | | | | |
| | НАМАР | | | | | | | | | | |
| 1 | 1-р бригад нөхөн тарилт | 40 | 750 | 790 | 0 | 0 | 0 | 0 | 2014-09-18-21 | Нөхөн тарилтанд | 790 |
| 2 | 2-р бригад нөхөн тарилт | 794 | 4716 | 5510 | 0 | 0 | 0 | 0 | 2014-09-23-27 | Нөхөн тарилтанд | 5510 |
| 3 | 3-р бригад нөхөн тарилт | 2130 | 3130 | 5260 | 0 | 0 | 0 | 0 | 2014-08-28—9-04 | Нөхөн тарилтанд | 5260 |
| 4 | 4-р бригад нөхөн тарилт | 3948 | 8380 | 12328 | 0 | 0 | 0 | 0 | 2014-09-08-17 | Нөхөн тарилтанд | 12328 |
| 5 | 6-р бригад нөхөн тарилт | 594 | 2649 | 3243 | 0 | 0 | 0 | 0 | 2014-09-27-30 | Нөхөн тарилтанд | 3243 |
| 6 | Сумын үзэсгэлэн худалдаанд | 10 | 40 | 50 | 20 | 20 | 20 | 0 | 2014-09-04 | | 110 |
| 7 | Аймгийн үзэсгэлэн худалдаанд | 20 | 90 | 110 | 30 | 20 | 20 | 0 | 2014-09-12---14 | | 180 |
| 8 | Баянхонгор | 314 | 2740 | 3054 | 0 | 0 | 0 | 0 | 2014-09-20 | Отгонбаяр | 3054 |
| 9 | Жавзмаа, Өв, Бат-Өлзий сум | 2 | 18 | 20 | 0 | 0 | 0 | 0 | 2014-09-29 | Худалдаж | 20 |
| 10 | Улаанбаатар ХААЖДҮГазарт | | | 15725 | 0 | 0 | 0 | 0 | 2014-09-20 | 2011, 2012, 2013 оны тендерийн үлдэгдэл | 53425 |
| 11 | Өвөрхангай ХААЖДҮГазарт | | | 1700 | 0 | 0 | 0 | 0 | 2014-09-20 | | |
| 12 | Баянхонгор ХААЖДҮГазарт | | | 28000 | 0 | 0 | 0 | 0 | 2014-09-20 | | |
| 13 | Улаанбаатар, Агрошижир ХХК | | | 8000 | 0 | 0 | 0 | 0 | 2014-09-20 | | |
| 14 | Конторын хашаа | 2 | 12 | 14 | 46 | 0 | 508 | 0 | 2014-09-26-27 | тохижилтонд | 568 |
| | Намрын дүн | 7854 | 22525 | 83804 | 96 | 40 | 548 | 0 | | | 84488 |
| | ОНЫ БҮХ ДҮН | | | 249884 | 2777 | 340 | 838 | 230 | 877238 | 0 | 258169 |




## 2.3. Хавар болон намар суулгац гаргаж нийлүүлсэн талаар


Чацарганы болон бусад модлог ургамлын суулгацуудыг бойжуулгын талбайн хайрцагнаас ухаж гарган нийлүүлэх ажилд хавар 1-р бригад 32,9 хүн/өдөр хүчээр 150,8 хайрцагнаас 34615 ширхэг суулгацыг, 2-р бригад 34 хүн/өдөр хүчээр 120 хайрцагнаас 21833 ширхэг суулгацыг, 3-р бригад 39 хүн/өдөр хүчээр 199 хайрцагнаас 42873 ширхэг суулгацыг, 4-р бригад 58 хүн/өдөр хүчээр 257,7 хайрцагнаас 59259 ширхэг суулгацыг, 5-р бригад 52,5 хүн/өдөр хүчээр 216,1 хайрцагнаас 59175 ширхэг суулгацыг буюу нийт дүнгээрээ 216,4 хүн/өдөр хүчээр 943,6 хайрцагнаас 217755 ширхэг суулгацыг гараар ухаж гаргасан.

Бойжуулгын талбайгаас гаргасан суулгацыг хавар боож, зэрэглэж, тоолж ачих, гологдол суулгацыг нь перковлон хадгалах, буцааж тариалах, суулгац тоолж тараах зэрэг ажлуудад 1-р бригадаас 24 хүн/өдөр, 2-р бригадаас 11 хүн/өдөр, 3-р бригадаас 26 хүн/өдөр, 4-р бригадаас 27 хүн/өдөр, 5-р бригадаас мөн ажлыг болон суулгацыг хувинд савлан усалж, зөөж, ачих, талбайд суулгац тоолж тараах зэрэг ажилд 98 хүн/өдөр буюу нийтдээ 186 хүн/өдөр хүч зарцуулсан.



## 2.4. Хавар талбайд хийгдсэн ажлын талаар

1-р бригад 5,5 хүн/өдөр хүчээр 1645 ширхэг мод тариалах нүхийг гараар ухаж бэлтгээд, 8,5 хүн/өдөр хүчээр 1685 ширхэг үхэр нүдний суулгац тариалж, мөн 30,1 хүн/өдөр хүч зарцуулан нөхөн тариалалт хийсэн талбайд 10470 метр урт усалгааны шуудууг сэргээн ухаж гаргаад 8,5 хүн/өдөр хүч зарцуулан 14000 метр урт усалгааны шуудуугаар усалгаа хийсэн. 4-р бригад 4 хүн/өдөр хүчээр 1300 ширхэг мод тариалах нүхийг гараар ухаж бэлтгээд, мөн 4 хүн/өдөр хүчээр 990 ширхэг үхэр нүдний суулгац тариалж, 3,3 хүн/өдөр хүч зарцуулан нөхөн тариалалт хийсэн талбайд 11415 метр урт усалгааны шуудууг сэргээн ухаж гаргаад 17,5 хүн/өдөр хүч зарцуулан 23700 метр урт усалгааны шуудуугаар усалгаа хийсэн.



## 2.5. Хаврын бусад  ажлын талаар





Мод тооллого явуулах, эх ба жимст цэцэрлэгийн тоологдох ёстой модонд тэмдэг тавих зэрэг ажлуудад 84 хүн/өдөр хүч зарцуулсан.

Гал тогоонд ажиллах зэрэг аж ахуйн ажилд нийтдээ 4-р сард 12 хүн/өдөр зарцуулсан.

Талбайг тойрсон харуул хамгаалалтын цэгүүдэд манаа гаргах ажилд 4-р сард 1-р бригад 12 хүн/өдөр, 2-р бригад 12 хүн/өдөр, 3-р бригад 16 хүн/өдөр, 4-р бригад 18 хүн/өдөр, 5-р бригад 10,5 хүн/өдөр буюу нийт дүнгээрээ 68,5 хүн/өдөр зарцуулсан.

5-р сард гаргасан суулгац  тоолж, боож, ачуулах, модонд пайз зүүж тооллого хийх, хяруунаас хамгаалалт тавих зэрэг цагийн ажлуудад 1-р бригад 79,4 хүн/өдөр хүч, 2-р бригад 37 хүн/өдөр хүч, 3-р бригад 55 хүн/өдөр хүч, 4-р бригад 14 хүн/өдөр хүч, 5-р бригад 43 хүн/өдөр хүч буюу нийтдээ 228,4 хүн/өдөр хүч зарцуулсан.

15 хүн хүчээр 6 хоногийн турш 4-р станцын хажууд хураалттай байсан труба цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. 800, 720, 630, 520, 400, 200, зэрэг мм диаметртэй, 11метр урттай гадаргуугаараа 1см хүртэлх зузаан хар лактай 100 гаруй трубаг хүрзээр хусан цэвэрлэв.

Талбай цэвэрлэх, гращд төмөрийн хог машинд ачих, хашаа барих, шон хураах, бойжуулгын талбайд усалгааны шуудуу гаргаж буй тракторт чиг гаргаж зогсох, алимны модны хучлага авах, гал тогоонд тогооч хийх зэрэг аж ахуйн ажилд 5-р сард 1-р бригад 4,5 хүн/өдөр, 2-р бригад 2 хүн/өдөр,  4-р бригад 14 хүн/өдөр, 5-р бригад 21 хүн/өдөр буюу нийт 41,5 хүн/өдөр зарцуулав. 2, 3, 4, 5-р талбайнуудад баруун талаасаа нэг нэг га буюу нийт 4 га талбайд 44 хүн/өдөр хүчээр мөр хоорондын шижим устгасан. Мөн 25,5 хүн/өдөрт 36900 ширхэг жимст цэцэрлэгийн модонд усалгааны дараахь эхний сийрүүлэлтийг хийсэн.



## 3. 2014 оны хавар урд 33 хүлэмж ба Ротаригийн 35 хүлэмжнээс гаргасан тарьцын тариалалт, ургалтын үеийн арчилгаа, суулгацын тараалтын талаар






2014 оны хавар 4-р сарын 7 –с эхлэн хүлэмжинд буй тарьцуудын нахиа задарч эхэлсэн.

2014 онд хүлэмжний тарьц тариалах талбайг "Буудай сан"-гийн трактороор 4-р сарын 29 -нд хагалуулсан.

Хайрцаг бэлтгэх ажилд 5-р сард 3-р бригад 149 хүн/өдөр хүчээр 1046, 4-р бригад 135,1 хүн/өдөрт 703 буюу нийт дүнгээрээ 284,1 хүн/өдөрт 1749 ширхэг 5 Х 5 хэмжээтэй хайрцагийг 5-р сарын 2-15 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн.

Мөн хугацаанд 1-р бригад 48,7 хүн/өдөрт 327,5, 5-р бригад 105,5 хүн/өдөрт 683,4 буюу нийт дүнгээрээ 154,2 хүн/өдөрт 1011 ширхэг 5 Х 5 хэмжээтэй хайрцагийг дахин нэмж хийн Ротаригаас гаргасан суулгацыг тариалж гүйцээсэн.

5-р сарын 14-25-ны хооронд 1,2 ба 5-р бригадын хүчээр хүлэмжнээс тарьц гаргах ажил хийгдсэн. 1-р бригад 48,7 хүн/өдөрт 296 нуруунаас 82791 ширхэг тарьцийг, 2-р бригад 8,5 хүн/өдөрт 72,1 нуруунаас 12199 ширхэг тарьцийг, 5-р бригад 37 цэцэрлэгчийн хүчээр буюу 110,4 хүн/өдөрт 2199,5 нуруунаас 405531,5 ширхэг тарьцийг тус тус ухаж гаргасан. Мөн 5-р бригад Ротаригийн 35 хүлэмжнээс 165,9 хүн/өдөрт 2550,4 нуруунаас 983826 ширхэг тарьцийг 5-р сарын 19-25-ны хооронд ухаж гарган тариалагч бригадуудад тоолж, ялгаж, багцлан хүргүүлсэн



## 2014 оны хавар урд 33 хүлэмж ба Ротаригийн 35 хүлэмжнээс гаргасан тарьцын тариалалт, ургалтын үеийн арчилгаа, суулгацын тараалтын талаар

2014онд урд хүлэмжнээс тарьц ухаж гаргасан байдлыг дараах хүснэгтээр үзүүлэв.

| Хүлэмж-ийн дугаар | Хүлэмж-ийн хэмжээ | Тариалт | | Тариалсан тоо | Ухаж | | Тариалсан суулгацын зарцуулалт | | Ухаж гаргасан нийт тоо | Амьдралтын цэвэр хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эхэлсэн огноо | дууссан огноо | | эхэлсэн огноо | дууссан огноо | 1-р | 2-р | | |
| 1 | 6X40 | 30.VI | 01.VII | 63260 | 14.V | 14.V | 33401 | 4735 | 38136 | 60,28 |
| 2 | 6X40 | 30.VI | 01.VII | 61070 | 14.V | 15.V | 32820 | 2350 | 35170 | 57,59 |
| 3 | 6X40 | 01.VII | 02.VII | 58330 | 15.V | 15.V | 33500 | 1700 | 35200 | 60,35 |
| 4 | 6X40 | 01.VII | 02.VII | 51939 | 15.V | 15.V | 30200 | 6029 | 36229 | 69,75 |
| 5 | 6X40 | 01.VII | 02.VII | 58090 | 15.V | 15.V | 28000 | 2507 | 30507 | 52,52 |
| 6 | 6X30 | 15.VII | 16.VII | 40910 | 17.V | 17.V | 11253 | 5027 | 16280 | 39,79 |
| 7 | 6X30 | 15.VII | 15.VII | 41656 | 17.V | 17.V | 8290 | 300 | 8590 | 20,62 |
| 8 | 6X40 | 14.VII | 15.VII | 55380 | 17.V | 17.V | 7193 | 3405 | 10598 | 19,14 |
| 9 | 6X40 | 14.VII | 15.VII | 57240 | 17.V | 17.V | 8360 | 0 | 8360 | 14,61 |
| 10 | 6X40 | 14.VII | 14.VII | 61365 | 17.V | 17.V | 10160 | 0 | 10160 | 16,56 |
| 11 | 6X40 | 14.VII | 14.VII | 60488 | 17.V | 17.V | 9600 | 0 | 9600 | 15,87 |
| 12 | 6X40 | 15.VII | 16.VII | 57260 | 17.V | 17.V | 12260 | 0 | 12260 | 21,41 |
| 13 | 6X30 | 16.VII | 16.VII | 42000 | 17.V | 18.V | 6463 | 0 | 6463 | 15,39 |
| 14 | 6X30 | 16.VII | 16.VII | 39150 | 18.V | 18.V | 7640 | 0 | 7640 | 19,51 |
| 15 | 6X30 | 16.VII | 16.VII | 47690 | 18.V | 18.V | 10433 | 0 | 10433 | 21,88 |
| 16 | 6X30 | 16.VII | 17.VII | 43340 | 18.V | 18.V | 8100 | 0 | 8100 | 18,69 |
| 17 | 6X30 | 17.VII | 18.VII | 28560 | 19.V | 19.V | 8897 | 0 | 8897 | 31,15 |
| 18 | 6X30 | 17.VII | 18.VII | 45493 | 19.V | 19.V | 13400 | 0 | 13400 | 29,46 |
| 19 | 6X30 | 18.VII | 18.VII | 45260 | 19.V | 19.V | 13080 | 0 | 13080 | 28,90 |
| 20 | 6X30 | 18.VII | 18.VII | 42105 | 19.V | 19.V | 4000 | 0 | 4000 | 9,50 |
| 21 | 6X30 | 19.VII | 19.VII | 42660 | 19.V | 19.V | 8746 | 0 | 8746 | 20,50 |
| 22 | 6X30 | 19.VII | 22.VII | 42500 | 19.V | 19.V | 10125 | 0 | 10125 | 23,82 |
| 23 | 6X30 | 19.VII | 22.VII | 39000 | 19.V | 19.V | 8464 | 0 | 8464 | 21,70 |
| 24 | 6X30 | 19.VII | 19.VII | 44522 | 19.V | 19.V | 9363 | 0 | 9363 | 21,03 |
| 25 | 6X30 | 19.VII | 22.VII | 41152 | 18.V | 18.V | 10408 | 0 | 10408 | 25,29 |
| 26 | 6X30 | 17.VII | 17.VII | 42416 | 18.V | 18.V | 9101 | 0 | 9101 | 21,46 |
| 27 | 6X30 | 17.VII | 18.VII | 40593 | 18.V | 18.V | 9940 | 0 | 9940 | 24,49 |
| 28 | 6X30 | 17.VII | 18.VII | 24512 | 18.V | 18.V | 7690 | 0 | 7690 | 31,37 |
| 29 | 6X30 | 22.VII | 22.VII | 32290 | 19.V | 20.V | 16765 | 0 | 16765 | 51,92 |
| 30 | 6X30 | 22.VII | 22.VII | 48640 | 19.V | 20.V | 13860 | 0 | 13880 | 28,54 |
| Эр тарьц | | | | 290764 | | | | | 77751 | |
| Эм тарьц | | | | 1108107 | | | | | 174592 | |
| Үүнээс сорт тодорхойгүй | | | | 292689 | | | | | 175242 | |
| Нийт | | | | 1398871 | | | 401532 | 26053 | 427585 | 29.77 |



## 2014 оны хавар урд 33 хүлэмж ба Ротаригийн 35 хүлэмжнээс гаргасан тарьцын тариалалт, ургалтын үеийн арчилгаа, суулгацын тараалтын талаар

2014онд Ротаригийн хүлэмжнээс тарьц ухаж гаргасан байдлыг дараах хүснэгтээр үзүүлэв.

| Хүлэмж-ний дугаар | Хүлэмж-ний хэмжээ | Тариалт | | Тариалсан тоо | Ухаж | | Тариалсан суулгацын зэрэглэл | | Ухаж гаргасан нийт тоо | Амьдралтын цэвэр хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эхэлсэн огноо | дууссан огноо | | эхэлсэн огноо | дууссан огноо | 1-р | | | |
| 1 | 6Х30 | 25.VII | 25.VII | 42720 | 19.V | 20.V | 25700 | | 25700 | 60,2 |
| 2 | 6Х30 | 25.VII | 25.VII | 45380 | 19.V | 20.V | 27440 | | 27440 | 60,5 |
| 3 | 6Х30 | 26.VII | 26.VII | 45040 | 20.V | 20.V | 28617 | | 28617 | 63,5 |
| 4 | 6Х30 | 26.VII | 27.VII | 46420 | 20.V | 20.V | 31650 | | 31650 | 68,2 |
| 5 | 6Х30 | 27.VII | 28.VII | 49648 | 20.V | 20.V | 23845 | | 23845 | 48,0 |
| 6 | 6Х30 | 19.VII | 19.VII | 57500 | 20.V | 20.V | 35850 | | 35850 | 62,3 |
| 7 | 6Х30 | 19.VII | 22.VII | 51642 | 20.V | 20.V | 35891 | | 35891 | 69,5 |
| 8 | 6Х30 | 22.VII | 25.VII | 46764 | 20.V | 20.V | 30110 | | 30110 | 64,4 |
| 9 | 6Х30 | 26.VII | 27.VII | 53043 | 21.V | 21.V | 24213 | | 24213 | 45,6 |
| 10 | 6Х30 | 26.VII | 27.VII | 49727 | 21.V | 21.V | 21320 | | 21320 | 42,9 |
| 11 | 6Х30 | 26.VII | 27.VII | 50470 | 21.V | 21.V | 27955 | | 27955 | 55,4 |
| 12 | 6Х30 | 26.VII | 27.VII | 57724 | 21.V | 22.V | 28730 | | 28730 | 49,8 |
| 13 | 6Х30 | 25.VII | 26.VII | 55780 | 21.V | 22.V | 31500 | | 31500 | 56,5 |
| 14 | 6Х30 | 31.VII | 06.VШ | 44959 | 26.V | 26.V | 22700 | | 22700 | 50,5 |
| 15 | 6Х30 | 25.VII | 26.VII | 56582 | 21.V | 22.V | 33540 | | 33540 | 59,3 |
| 16 | 6Х30 | 15.VII | 15.VII | 51320 | 21.V | 22.V | 37500 | | 37500 | 73,1 |
| 17 | 6Х30 | 16.VII | 16.VII | 52095 | 21.V | 22.V | 37500 | | 37500 | 72,0 |
| 18 | 6Х30 | 16.VII | 17.VII | 50380 | 22.V | 22.V | 35730 | | 35730 | 70,9 |
| 19 | 6Х30 | 18.VII | 19.VII | 57260 | 22.V | 22.V | 33350 | | 33350 | 58,2 |
| 20 | 6Х30 | 18.VII | 19.VII | 60195 | 22.V | 22.V | 31810 | | 31810 | 52,8 |
| 21 | 6Х30 | 27.VII | 28.VII | 56462 | 22.V | 23.V | 30445 | | 30445 | 53,9 |
| 22 | 6Х30 | 26.VII | 28.VII | 51220 | 23.V | 23.V | 24795 | | 24795 | 48,4 |
| 23 | 6Х30 | 27.VII | 28.VII | 51140 | 23.V | 23.V | 31200 | | 31200 | 61,0 |
| 24 | 6Х30 | 28.VII | 29.VII | 47692 | 23.V | 23.V | 23700 | | 23700 | 49,7 |
| 25 | 6Х30 | 29.VII | 30.VII | 49520 | 26.V | 26.V | 22668 | | 22666 | 45,8 |
| 26 | 6Х30 | 29.VII | 30.VII | 56110 | 26.V | 26.V | 22520 | | 22520 | 40,1 |
| 27 | 6Х30 | 29.VII | 30.VII | 55530 | 26.V | 26.V | 22600 | | 22600 | 40,7 |
| 28 | 6Х30 | 28.VII | 29.VII | 50220 | 23.V | 23.V | 27270 | | 27270 | 54,3 |
| 29 | 6Х30 | 29.VII | 06.VШ | 55650 | 23.V | 23.V | 29700 | | 29700 | 53,4 |
| 30 | 6Х30 | 29.VII | 06.VШ | 52212 | 23.V | 23.V | 19440 | | 19440 | 37,2 |
| 31 | 6Х30 | 30.VII | 06.VШ | 54770 | 25.V | 25.V | 24500 | | 24500 | 44,7 |
| 32 | 6Х30 | 30.VII | 02.VШ | 49280 | 25.V | 25.V | 28265 | | 28265 | 57,4 |
| 33 | 6Х30 | 30.VII | 06.VШ | 55400 | 25.V | 25.V | 34500 | | 34500 | 62,3 |
| 34 | 6Х30 | 02.VШ | 02.VШ | 59320 | 25.V | 25.V | 28320 | | 28320 | 47,7 |
| 35 | 6Х30 | 06.VШ | 06.VШ | 54555 | 25.V | 25.V | 8954 | | 8954 | 16,4 |
| Эр тарьц | | | | 424889 | | | | | 215025 | |
| Эм тарьц | | | | 1398841 | | | | | 768801 | |
| Нийт | | | | 1823730 | | | | | 983826 | 54,1 |



## 2014 оны хавар урд 33 хүлэмж ба Ротаригийн 35 хүлэмжнээс гаргасан тарьцын тариалалт, ургалтын үеийн арчилгаа, суулгацын тараалтын талаар

Нийт дүнгээрээ 5 бригад 811,8 хүн/өдөр хүчээр нийтдээ 1 451 952 ширхэг тарьцыг, 2684 хайрцагт тариалж, 105,7 хүн/өдөр хүчээр 3065,8 хайрцагт давхардсан тоогоор усалгаа хийсэн. Энэ нь дунджаар нэг хүн/өдөрт 1788,5 тарьцыг 3,3 хайрцагт тариалж, 29 хайрцагтай суулгацыг усалсан гэсэн үг юм.

Бойжуулгын талбайн тариалалт дууссаны дараа бойжуулгын талбайг агроном Мэнддолгорын 5-р бригадад нийт талбайг хуваарилж өгөн хариуцуулсан. Мөн өмнөх жилийн суулгац байсан 10Б талбайн 447 хайрцагтай суулгацыг 6-р бригадад хариуцуулан өгсөн ба тус бригадын 9 цэцэрлэгчээр 6-р сард услуулсан.

6-р сард 5-р бригадын 39 цэцэрлэгч 3 өдөрт 117,5 хүн/өдөр хүч зарцуулж энэ жил шинээр тарьц тариалсан нийт 2953 хайрцагт тарьцын гүн сийрүүлэлтийн ажилбар хийлгэсэн. Мөн хайрцагтай тарьцын 2-р усалгааг 39 цэцэрлэгч 3 өдөрт 113,5 хүн/өдөр хүч зарцуулж нийтдээ 5914 хайрцагт хийсэн. Хайрцагны хамрын зэрлэгийг гараар түүж авах ажилбарыг 23 цэцэрлэгч 3 өдөрт 107,5 хүн/өдөр хүч зарцуулж 3957 хайрцагт хийлгэсэн. Хайрцагны зэрлэгийг гараар түүж авах ажилбарыг 23 цэцэрлэгч 47 хүн/өдөр хүч зарцуулж 1157 хайрцагт хийлгэсэн.

6-р сард 6-р бригадын 4 хүн/өдөр хүчээр 1887 метр урт усалгааны шуудууг шинээр ухаж гаргаад 9 хүн/өдөр хүчээр өмнөх жилийн болон энэ жил шинээр тарьц тариалсан нийт 447 хайрцгийг сувгаар усалж, 1 хүн/өдөр хүчээр 26 хайрцагтай суулгацад гүн сийрүүлэлт хийж, 190 хайрцагны хамрын зэрлэгийг гараар түүж авах ажилбарыг 5 хүн/өдөр хүчээр хийлгэсэн.

7-р сард 5-р бригадын 146,1 хүн/өдөр хүчээр нийт 4000 хайрцагт тарьцын гүн сийрүүлэлтийн хөрс боловсруулах ажилбар хийлгэсэн. Мөн 137,4 хүн/өдөр хүчээр нийт 6598 хайрцагт усалгаа хийгээд хоёроос гурав хоногийн дараа хайрцагтай тарьцын усалгааны дараах өрөмтөлт арилгах мөр хоорондын маажилт боловсруулалтыг 4,5 хүн/өдөр хүчээр нийт 204 хайрцагт хийлгэсэн. Нийтдээ 4384 хайрцагны хамар, шуудууны зэрлэгийг 110 хүн/өдөр хүчээр гараар түүлгэж, хайрцаг доторх ургамал хоорондын зэрлэгийг 167,5 хүн/өдөр хүчээр нийт 5061 хайрцагнаас мөн л гараар түүлгэж авахуулсан.



## 2014 оны хавар урд 33 хүлэмж ба Ротаригийн 35 хүлэмжнээс гаргасан тарьцын тариалалт, ургалтын үеийн арчилгаа, суулгацын тараалтын талаар

2012-2014 суулгацны тоог хүснэгтээр харуулсан нь:

| Тариалсан огноо | Тариалсан модны төрөл | Талбайн дугаар | Хайрцагны тоо | Суулгацын тоо | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 2010 | хайлаас | 10 | 96 | 8195 | = |
| 2010-2013 | Улиас | 7,10 | 224 | 36153 | = |
| 2012 | чацаргана | 10 | 144 | 14372 | энэ 2014 онд гаргасан |
| 2012 | эр чацаргана | 7 | 96 | 20252 | = |
| 2012 | чацаргана | 6б | 1167 | 217508 | = |
| 2012 | 37мөр | 5б | | 104532 | = |
| 2013 | эм чацаргана | 7б | 2271 | 548816 | = |
| 2013 | эр чацаргана | 3б | 442 | 89222 | = |
| 2013-2014 | Үхэр нүд | 10б | 98 | 32171 | = |
| 2014 | чацаргана | 2б | 1850 | 1051016 | = |
| | | | | | |
| Нийт | хайлаас | | | 8195 | |
| Нийт | улиас | | | 36153 | |
| Нийт | Үхэр нүд | | | 32171 | |
| Нийт | эр чацаргана | | | 109474 | |
| Нийт | эм чацаргана | | | 1599832 | |
| Нийт | чацаргана | | | 2981718 | |
| Бүгд | | | | 3058237 | |

Бойжуулгын нийт талбайд 3 сая ширхэг суулгац тоологдсон. Үүнээс чацаргана нийтдээ 2,9 сая ширхэг байгаа юм.



## 2014 оны хавар урд 33 хүлэмж ба Ротаригийн 35 хүлэмжнээс гаргасан тарьцын тариалалт, ургалтын үеийн арчилгаа, суулгацын тараалтын талаар

7-р сард 6-р бригадын 12,2 хүн/өдөр хүчээр монос, үхэр нүд, улиас тариалсан нийт 197 хайрцагт усалгаа хийсэн. Мөн 58 хайрцагны хамар, шуудууны болон доторх зэрлэгийг 10,3 хүн/өдөр хүчээр гараар түүлгэж авахуулсан.

Ургалтын улиралын туршид бойжуулгын талбайд нийтдээ 11 удаа усалгаа, арчилгаа хийлгэсэн. Үүнээс 2 удаагийн усалгаа нь эрдэс ба органик бордоотой хамтатгасан байв. Органик бордоог бэлтгэхдээ бууц, сангасыг 2 : 1 харьцаагаар хийгээд жигд найруулан хольж ус нэмэн 60 хувийн уусмал бэлтгээд нэг хайрцагт нэг усалгаан дээр 0,5 л хэмжээгээр усалгааны устай хамтатган өгч байв.

Ажиллах хүн хүч дутагдалтай байсан учир 17-23 хүртэлх насны 10 гаруй оюутан, сурагчидыг бойжуулгын ба бусад бригадад авч ажиллуулсан.

Бойжуулгын талбайн арчилгааг 1 өдөрт усалгаа, 2 өдөрт өнгөн маажилт хийх, 4 өдөрт гүн сийрүүлэлт хийх, 2 өдөрт хамар шуудууны болон мод хоорондын зэрлэг авах, 1 өдөр хамар шуудууг усалгаанд бэлтгэх гэсэн 10 хоногийн графикаар ургалтын хугацааны туршид хийсэн.

8-р сард 5-р бригадын 42 цэцэрлэгч 124 хүн/өдөр хүчээр 4946 хайрцагны хамар, шуудууны зэрлэгийг, 3589 хайрцаг доторх ургамал хоорондын зэрлэгийг 37 цэцэрлэгч 3,5 хоногт буюу 125 хүн/өдөр хүчээр мөн л гараар түүлгэж авахуулсан. Мөн 37 цэцэрлэгч 58,5 хүн/өдөр хүчээр нийт 2558 хайрцагт усалгаа хийлгэсэн.

8-р сард 6-р бригадын 5,6 хүн/өдөр хүчээр 192 хайрцагны хамар, шуудууны зэрлэгийг, 181,5 хайрцаг доторх ургамал хоорондын зэрлэгийг 5,6 хүн/өдөр хүчээр мөн л гараар түүлгэж авахуулсан.

9-р сард 5-р бригадын 10 хүн/өдөр хүчээр нийт 240 хайрцагт тарьцын гүн сийрүүлэлтийн хөрс боловсруулах ажилбар хийлгэсэн. 360 хайрцагны хамар, шуудууны зэрлэгийг 10 хүн/өдөр хүчээр гараар түүлгэж, хайрцаг доторх ургамал хоорондын зэрлэгийг мөн л 10 хүн/өдөр хүчээр 280 хайрцагнаас гараар түүлгэж авахуулсан. 10 хүн/өдөр хүчээр бойжуулгын 480 хайрцагт наймдугаар усалгааг хийлгэсэн.

10-р сард 5-р бригадын 38,2 хүн/өдөр хүчээр бойжуулгын 1897 хайрцагт сүүлчийн усалгааг хийлгэсэн.



## 2014 оны хавар урд 33 хүлэмж ба Ротаригийн 35 хүлэмжнээс гаргасан тарьцын тариалалт, ургалтын үеийн арчилгаа, суулгацын тараалтын талаар



11-р сард 5-р бригадын 17 хүн өдөр хүчээр 43,5 хайрцагнаас, 11349 ширхэг тендерийн суулгац гаргаж, боож баглан ачиж явуулах ажил хийж гүйцэтгэсэн.

Намар нийтдээ гадагш 9 –р сарын 4–29-ний хооронд суулгац ухаж нийлүүлсэн. Үлдсэн бойжуулгын талбайн гадуур шон суулган тор татаж өвөлжилтөнд бэлтгэсэн.

| № | Үзүүлэлт | Суулгацын төрөл, тоо ( ширхэгээр ) | | | | | | | Олгосон огноо | Олгосон хэлбэр | Нийлүүл-сэн нийт тоо (ш) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Чацаргана | | | Үхэр нүд | Улиас | Хайлаас | Цагаан бургас | | | |
| | | эр | эм | Нийт | | | | | | | |
| | НАМАР | | | | | | | | | | |
| 1 | Сумын үзэсгэлэн худалдаанд | 10 | 40 | 50 | 20 | 20 | 20 | 0 | 2014-09-04 | | 110 |
| 2 | Аймгийн үзэсгэлэн худалдаанд | 20 | 90 | 110 | 30 | 20 | 20 | 0 | 2014-09-12---14 | | 180 |
